

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**ДОКУМЕНТЫ ОПРОВЕРГАЮТ ПРОТИВ ФАЛЬСИФИКАЦИИ
ИСТОРИИ РУССКО-КИТАЙСКИХ ОТНОШЕНИИ. (сб. статей) М. 1982**

1970-аад оны 2-р хагасаас эхлэн БНХАУ-д орос-хятадын харилцааг бүдүүлгээр мушгин гуйвуулсан ном, өгүүлэл цөөнгүй гарав.¹ Энэ нь хятадын үндсэрхэг үзэлтнүүдийн өргөн сурталчилж байгаа түүхийн эсрэг, худал хуурмаг зүйлүүдийг хөдөлшгүй баримтын үндсэн дээр илчлэн няцаах явдлыг өнөөгийн чухал зорилт болгон дэвшүүлж байна. Зөвлөлтийн хэсэг түүхч-хятад судлаачдын бичиж академич С. Л. Тихвинскийн редакторласан «Баримт няцааж байна. Орос-Хятадын харилцааны түүхийг гуйвуулахын эсрэг» хэмээх өгүүлүүдийн эмхтгэл түүхэн үнэнийг сэргээн хамгаалах энэхүү ариун зорилгод чиглэгдсэн юм.

Хятадын маоист түүхчид XVII зууны дундаас XIX зууны 70—80-аад он хүртлэх орос-хятадын харилцааны шинж чанарыг мушгин гуйвуулж «хар тамхины» 1, 2-р дайны үед (1840—1842, 1856—1860) Хятадад дайран орсон капиталист Англи, Францын түрэмгий бодлогоос давсан хэт харгис түрэмгий бодлого явуулж байсан мэтээр Оросыг гүтгэн муучилж байна. Тэр ч байтугай хятадын зарим түүхчид Хятадтай хар тамхины худалдаа хийсэн, «хятадын унаган нутгуудыг» булаан эзэлсэн, XIX зууны дундуур Хятадад өрнөж байсан иргэний дайнд зэвсгийн хүчээр хөндлөнгөөс оролцсон гэх зэргийн гэм бурууг Оросын талд тохохыг оролдож байна.

Г. В. Мелиховын бичсэн тус эмхтгэлийн эхний хоёр өгүүлэл нь Приамурье ба Приморьег Хятадад «түүхийн хувьд харьяалагдах» тухай санаархлыг манж, хятад баримт сэлт дээр тулгуурлан үнэмшилтэй няцаажээ.

«Хоёр орны харилцааны эхний үед Хятадын талаар хаант Оросын явуулж байсан бодлогын гол агуулга нь эдийн засгийн дээрэм тонуул байв» гэсэн Орос-хятадын худалдааны шинж чанарыг гуйвуулсан дүгнэлтийг А. Н. Хохловын «Хиагтын худалдаа болон Орос ба Хятадын бодлогонд түүний эзлэх байр (XVIII зууны 20-иод он—XIX зууны 50-иад он)» өгүүлэл ЗХУ, БНМАУ-ын архивуудын материалын үндсэн дээр илчлэн няцааж байна. Орос, хятадын худалдаачдын хооронд явагдаж байсан наймаа нь харилцан ашигтай байсан бөгөөд харин ч оросын тал худалдааны хэлхээ холбоог хэвээр байлгахын тулд манж Чин улсын буруугаар шийдэгдээгүй олон тооны асуудлыг хойш тавихад хүрч байсныг зохиогч өгүүлжээ. Н. Антоновын өгүүлэлд Хятадын баруун хязгаарт явагдаж байсан орос-хятадын худалдаа болон 1851 оны Кульджийн гэрээний байгуулагдсан түүхийг авч үзжээ. Манжийн засгийн газар харилцан ашигтай худалдааг хяхан хавчиж, хятад ба оросын ард

¹ «Хаант Оросоос Хятадыг түрэмгийлсэн түүх» 1. 2-р боть. Бээжин. 1978, «Хаант Оросын түрэмгийлэл дэлгэрсний түүх» 1-р боть, Бээжин. 1979 (хятад хэл дээр).

түмнүүдийн хооронд сайн хөршийн харилцаа тогтоход саад учруулж байжээ.

А. А. Брежнев «Орос ба тайпыны тариачдын дайн» өгүүлэлдээ Орос нь Англи, Францтай хамтран 1850—1864 оны Тайпыны тариачдын дайныг дарахад оролцсон мэтээр Бээжингийн түүхчдийн гүтгэснийг няцаахын хамт Оросын ардчилсан хувьсгалчид ба дэвшилт олон нийт Чин улсын дарлалын эсрэг боссон хятадын ард түмнийг талархан дэмжиж өрнөдийн орнуудын зэвсэгт оролцоог хилэгнэн эсэргүүцэж байсныг үзүүлжээ.

Хятадын эсрэг Англи, Францын өдөөсөн «хар тамхины» 2-р дайны (1856—1860 оны) үед Оросын эзлэж байсан байр суурь, Оросоос Хятадад үзүүлсэн тусламжийн тухай бодит үнэнийг өгүүлэхэд С. И. Повальников, А. Н. Хохлов нар тус тусын өгүүллээ зориулжээ.

Орос нь Дундад Азид хар тамхи тарьж ургуулан Хятадад оруулж байсан буюу XVII зууны 90-ээд оноос эхлэн оросын худалдаачид Хятадаас нутгийн уугуул оршин суугчдыг Орост аваачин худалдаалж хамжлагын эздийн зарц болгож байсан гэх мэтийн ямар ч ор үндэсгүй, бүдүүлэг гүжир гүтгэлэг Бээжиид хэвлэгдсэн ном, зохиолуудад байр эзэлж байна. Энэ асуудлуудыг хөндсөн Г. Н. Песковын хоёр өгүүлэлд зөвхөн Оросын дэвшилт олон нийт төдийгүй албаны хүмүүс хүртэл хар тамхины худалдаа болон хятадын хар ажилчид (кули) худалдаалах явдлыг эрс буруушааж хориглож байсныг батлан харуулжээ.

1871—1881 онд Синьцзяний уугуул ард түмнээс манж-хятадын колоничлогчдын эсрэг хийсэн хүчит бослогын үеэр Илийн хязгаарт оросын цэрэг түр орж байрласан тухай асуудлыг хятадын түүхчид өөрсдийн явцуу зорилгод ихээхэн ашиглах болов. «Илийн асуудлын» түүх ба хятадын гуйвуулагчид» гэсэн өгүүлэлдээ Б. П. Гуревич Илийн хязгаарт Орос нь «колонийн ноёрхлын цуст дэглэм» тогтоосон бөгөөд «Илийн хязгаарын үндэстэн бүрийн ард түмэн бүх орны ард түмний дэмжлэгтэй баатарлаг тэмцлийг хийж байсан юм» гэх мэтийн маоист түүхчдийн санаанаасаа зохиосон гүтгэлгүүдийг няцаасан олон тооны баримт сэлтийг оруулсан байна. XIX зууны 70-аад онд англи-оросын зөрчил хурцадсан нөхцөлд олон улсын харилцааны төвөгтэй байдалд «Илийн асуудал» гэдэг нь гарч иржээ. Чин улсын дарангуйлагчид манж-хятадын дарлалын эсрэг боссон Зүүнгар болон Дорнод Туркестаны уугуул хүн ам уйгур, дунган нарыг цус урсган харгислаж мөн Оросын казах ба дундад азийн эзэмшил газарт аюул занал учруулж байсны чацуу Цзо Цзунтаны залхаан цээрлүүлэх арми Английн шууд дэмжлэгтэйгээр оросын нутаг дэвсгэрт цэрэглэн халдахаар зэхэж байсныг Оросын засгийн газар тэр үед анхааран үзэж сөрөг арга хэмжээ авахаас өөр аргагүй байдалд хүрчээ. Мөн 1881 оны Орос-хятадын Петербургийн гэрээгээр Оросын мэдэлд шилжсэн газар нутагт өнгөлзөх ямар ч түүхэн эрх Хятадын талд үгүй болохыг уг өгүүлэлд хөдөлшгүй баримтаар нотлон үзүүлжээ.

С. Н. Гончаренкогийн «XIX зууны 2-р хагаст Хятадаар аялсан оросын жуулчдын тухай» өгүүлэл нь Төв Азийн судлаач оросын нэрт жуулчид Н. М. Пржевальский, П. П. Семенов-Тянь-Шанский, Г. Н. Потанин нарын эрдэм шинжилгээний үйл ажиллагааг хятадын засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр Хятадын нутагт зэвсэглэн түрэмгийлсэн үйлдэл мэтээр гүтгэсэн Бээжингийн зохиогчдын оролдлогыг архивын материал дээр тулгуурлан няцаажээ. Орчин үеийн хятадын зохиогчид «бүх юм аль эрт нээгдсэн байсан» учраас энэ экспедицүүд шинжлэх ухааны ямар ч нээлт хийгээгүй гэх мэтээр гуйвуулахаас буцахгүй байна. Дэлхийн шинжлэх ухааныг хосгүй нээлтээр баяжуулсан оросын газар зүйн Төв

Азийн шинжилгээний ангиуд шинжлэх ухааны зорилготой бөгөөд хятадын засаг захиргааны зөвшөөрөлтэй явагдсаныг дээрх өгүүлэл нотлож өгчээ.

Академич С. Л. Тихвинский «Орос-Хятадын харилцааны түүхийг гуйвуулахын эсрэг» гэсэн оршил өгүүлэлдээ «Оросын хөгжлийн монополизмын өмнөх, империализмын өмнөх үе болох XIX зууны 70—80-аад он хүртэл Хятадын талаарх Оросын бодлого нь түүх, эдийн засаг, газар зүйн олон нөхцөлөөс шалтгаалан Англи, Францын бодлогоос эрс ялгаатай байсныг олон тооны баримт сэлт гэрчилж байна. Хятадын талаарх Оросын засгийн газрын бодлого нь үргэлж сайн хөршийн байсан»² гэдгийг цохон тэмдэглэсэн нь Оросын засгийн газрын бодлогын мөн чанар, түүнчлэн өнөө үед Зөвлөлт засгийн газраас явуулж байгаа энх тайванч бодлогыг гуйвуулсан хятадын түүхчдийн бүтэшгүй оролдлогод хатуу няцаалт өгч байна.

Орос-Хятадын харилцааны түүхийг мушгин гуйвуулсан хятадын сүүлийн үеийн ном, өгүүллүүдийг марксист-ленинист арга зүйн үүднээс задлан шинжилж, орос ба зөвлөлтийн эсрэг суртал ухуулгын арга хэлбэрийг илчлэн няцаасан, архивын баялаг материалыг ашиглан түүхэн үнэнийг сэргээн хамгаалсан энэхүү бүтээл нь цаг үеэ олсон, орос-хятадын харилцааны асуудлыг гүнзгийрүүлэн судлахад шинэ алхам хийсэн эрдэм шинжилгээ практикийн ач холбогдолтой чухал бүтээл болжээ.

Ц. Батбаяр

² Документы опровергают. Против фальсификации истории русско-китайских отношений. М., 1982, с. 7.